*Суралцахуйн зураглалтай ажиллах алхам:*



| | |
|---|---|
| I алхам | Багшийн зөвлөсөн дасгал, даалгавруудаас эхлэн суралцагч даалгаврыг ажиллах |
| II алхам | Өөрийн хийж чаддаг болсон дасгал, даалгавруудыг тохирох түвшний өнгөөр суралцагч будах |
| III алхам | Тухайн бүлгийн дасгал, даалгаврыг гүйцэтгэж эхэлсэн болон дуусгасан хугацааг суралцагч тэмдэглэх |
| IV алхам | Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа суралцагч өөрийгөө үнэлэх |
| V алхам | Багш суралцагчийн гүйцэтгэсэн дасгал, даалгаврыг үнэлж, зөвлөмж өгөх |

| Бүлэг | 7-р анги III түвшин | | | | | 8-р анги III түвшин | | | | 9-р анги III түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний эрх ба хууль | 7.3а | 7.3б | 7.3в | 7.3г | 7.3д | 8.3а | 8.б | 8.3в | 8.3г | 9.3а | 9.3б | 9.3в | 9.3г |
| Нийтийн удирдлага | 7.3а | 7.3б | | | | 8.3а | 8.3б | 8.3в | | 9.3а | 9.3б | 9.3в | |
| Эхэлсэн хугацаа | | | | | | | | | | | | | |
| Дуусcан хугацаа | | | | | | | | | | | | | |
| Өөрийн үнэлгээ | | | | | | | | | | | | | |
| Багшийн үнэлгээ | | | | | | | | | | | | | |

| Бүлэг | 7-р анги II түвшин | | | | | 8-р анги II түвшин | | | | | | | 9-р анги II түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний эрх ба хууль | 7.2а | 7.2б | 7.2в | 7.2г | 7.2д | 8.2а | 8.2б | 8.2в | 8.2г | 8.2д | 8.2е | 8.2ё | 9.2а | 9.2б | 9.2в | 9.2г | 9.2д |
| Нийтийн удирдлага | 7.2а | 7.2б | 7.2в | 7.2г | | 8.2а | 8.2б | 8.2в | 8.2г | 8.2д | 8.2е | | 9.2а | 9.2б | 9.2в | 9.2г | |
| Эхэлсэн хугацаа | | | | | | | | | | | | | | | | | |
| Дуусcан хугацаа | | | | | | | | | | | | | | | | | |
| Өөрийн үнэлгээ | | | | | | | | | | | | | | | | | |
| Багшийн үнэлгээ | | | | | | | | | | | | | | | | | |

| Бүлэг | 7-р анги I түвшин | | | | | | | 8-р анги I түвшин | | | | | | | | | | | | | | | 9-р анги I түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний эрх ба хууль | 7.1а | 7.1б | 7.1в | 7.1г | 7.1д | 7.1е | 7.1ё | 8.1а | 8.1б | 8.1в | 8.1г | 8.1д | 8.1е | 8.1ё | 8.1ж | 8.1з | 8.1и | 8.1й | 8.1к | 8.1л | | | 9.1а | 9.1б | 9.1г | 9.1д |
| Нийтийн удирдлага | 7.1а | 7.1б | 7.1в | 7.1г | 7.1д | 7.1е | 7.1ё | 8.1а | 8.1б | 8.1в | 8.1г | 8.1д | 8.1е | 8.1ё | 8.1ж | 8.1з | 8.1и | 8.1й | 8.1к | 8.1л | 8.1м | 8.1н | 9.1а | 9.1б | | |
| Эхэлсэн хугацаа | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Дуусcан хугацаа | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Өөрийн үнэлгээ | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| Багшийн үнэлгээ | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |



Даалгаврыг анхааралтай уншиж зааврын дагуу хийж гүйцэтгээрэй.

**8.1а.** Хүний эрхийн тухай үзэл санааг хүн төрөлхтөн үүсгэн хөгжүүлсэн. Хүний эрхийн түүх бий болсон гол шалтгаануудыг гүйцээж бичнэ үү.



- Дайн
- ..............................
- ..............................
- ..............................
- ..............................

**8.1б**. Дараах үсгүүдээс тухайн нэр томьёог бүтээж, тодорхойлолт дахь цэгийн оронд зөв нөхөн бичээрэй

У,Л,У,Ь,Х

Нийгэм, орон нутгийн болон хүмүүс хоорондын харилцааг зохицуулдаг гол хэм хэмжээ нь ................бөгөөд ................-н гол зорилго бол хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулах явдал юм.

**8.1в.** Дараах бүдүүвчийг ажиглаж, хүний эрхийн түгээмэл тунхаглалд баталгаажуулсан хүний эрхийн төрлүүдийг зөв нөхөж бичнэ үү.

...................... → Нас хүйс → .................... → Эд хөрөнгө

...................... → ........................ → Нийгмийн гарал

**8.1г.** Дэлхийн хоёрдугаар дайны учруулсан хор хохирол нь хүний эрхийг зайлшгүй хамгаалах гол шалтгаан болсон. Хүний эрхийг хамгаалахтай холбогдох дараах он ба үйл явдлыг зөв тохируулаарай.

| | |
| --- | --- |
| 1. 1945 онд | A. Нэгдсэн Үндэстний Байгууллагыг байгуулсан /НҮБ/ |
| 2. 1946 онд | B. НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан. |

**8.1д.** Хүний эрхийн түгээмэл тунхаглал гэж юу вэ? Өөрийн ойлголтоо бичнэ үү.



**8.1е.** Дараах бүдүүвчид Хүний эрхийн суурь баримт бичгүүдийн нэрийг зөв нөхөн бичээрэй.

Хүний эрхийн Билл - хүний эрхийн суурь баримт бичгүүд

1 ……
…….

2 ……
……

3 ……..
………

**8.1ё.** Хүмүүс хоорондын ялгаралыг тэдний нийгмийн шинж чанараас хамааруулан хоёр ангилна. Тайлбарлан бичээрэй.

**Төрөлхийн ялгарал**

**Төрөлхийн бус ялгарал**

**8.1ж.** Хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах ёстой үндсэн зарчмын нэг нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчим юм. Ялгаварлан гадуурхах гэдэгт юуг ойлгох вэ? Тодорхойлолтыг бичээрэй.



**8.1з.** Хүснэгтийг анхааралтай ажиглаад хүний эрхийг хангахтай холбоотой утгуудыг олж будаарай.



| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ү | Т | Ө | Р | У | Г | Ж | У | Ү | Й | П | Ю | В | О | Б |
| Н | Ө | Ө | Х | К | О | Н | В | Е | Н | Ц | А | Ч | А | Ж |
| Д | Х | Х | Ү | Ө | Ы | Б | Ө | У | Ж | А | В | В | Х | Э |
| С | Х | А | Н | Г | А | Х | Ү | Ү | Р | Э | Г | Х | Ы | Р |
| Э | Ц | У | И | Б | Й | Р | Ү | Ө | Ц | А | Х | Х | Ө | Х |
| Н | Ж | Ү | Й | Х | Ф | Н | Р | Ө | Ы | Г | Э | Ү | Ж | Э |
| Х | И | З | Э | А | Ц | Г | Э | Б | Б | Ү | У | Н | Э | Д |
| У | Р | Р | Р | Р | Ж | Ж | Г | Ы | Ө | Р | Ц | И | Ы | Л |
| У | Г | Ф | Х | Н | У | Ш | Х | Й | Й | О | А | Й | Ё | Э |
| Л | Э | Р | У | Э | Ө | Ү | Ү | Ц | Й | Л | Б | Э | Ч | Г |
| Ь | Н | Ү | У | Ж | Э | Ж | Л | У | Ы | В | Л | Р | Я | Ч |
| Э | Л | Ө | Л | У | Ж | О | Э | Р | Ө | Ю | О | Х | Е | Х |
| Х | Ү | Н | Д | Э | Т | Г | Э | Х | Ү | Ү | Р | Э | Г | Ү |
| У | Ы | Ы | А | Ц | О | У | Г | Т | Ё | У | Г | А | П | Н |
| Д | Ц | Э | Й | О | Р | Ц | Ч | Л | Т | А | Ш | А | Д | А |

**8.1и**. Эрх эдлэгч, үүрэг хүлээгч гэж хэн бэ? Дараах ойлголтууд ба үүрэг, хариуцлагын хамаарлыг зөв холбоорой.

Эрх эдлэгч



Бусдын эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ.

Үүрэг хүлээгч

САЙН ИРГЭН ИРЭЭДҮЙ

Хүний эрх зөрчигчдөд хариуцлага оногдуулах эрх хэмжээтэй.

**8.1й**. Зургийг ажиглаж, төрөөс иргэдэд үйлчилдэг нийгмийн үйлчилгээнээс нэрлэн бичнэ үү.











А ............................ Б. ............................ В. .............................. Г....................................

**8.1к**. Монгол улсын Үндсэн хууль нь манай улсын нийгэм, улс төр, засаглалын харилцааны үндсийг тодорхойлж, төрийн байгууламж, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан. Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт юуны тухай баталгаажуулсан бэ? Бичнэ үү.




2 бүлэг

**8.1л**. Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах хүн бүрд хүртээмжтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх механизм бол төр юм. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүргүүдийг нэрлэн бичээрэй.



1. Хүндэтгэх үүрэг
2. ................................................
3. ................................................
4. ................................................

2 од хэсэгт гүйцэтгэсэн даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан даалгаврын харгалзах дугаарыг, 1 хүсэл хэсэгт дутуу ойлгосон, ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичнэ үү.

| Хоёр од ⭐ ⭐ | Нэг хүсэл | Багшийн тэмдэглэл |
|---|---|---|
| | | |



8.2а. Дараах зураг ба бүдүүвчүүдийг ажиглаж, хүний эрхийн зарчим болон тодорхойлолт тус бүрийг зөв холбоорой.

| Зарчим | Тодорхойлолт | Зураг |
|---|---|---|
| 1. Хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчим | А. Ялгаатай байдлаас үл хамааран хүн бүрд хүндэтгэлтэй хандах ёстой | 1.  |
| 2. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим | Б. Иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрх нэгдмэл хуваагдашгүй байна. | 2.  |
| 3. Салшгүй байх зарчим | В. Хүний эрх нь төрөөс олгож буй хишиг биш, харин хүн төрж мэндлэхэд нь хамт заяадаг түүний төрөлх чанар юм. | 3.  |
| 4. Түгээмэл байх зарчим | Г. Хүний эрх нь хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлс тул дэлхийн бүх улс орон, бүс нутагт хүлээн зөвшөөрч нэг мөр ойлгож хэрэгжүүлэх ёстой. | 4.  |
| 5. Хуваагдашгүй байх зарчим | Д. Хүмүүс нас , хүйс, арьс үндэс, нийгмийн анги давхраа зэргээс үл хамааран хүн болон мэндэлснийхээ хувьд эрх тэгш байна. | 5.  |
| 6. Харилцан хамааралтай байх | Е. Хүн бүр бусдын эрхийг хүндэтгэх, хангах, эрхээ шаардах, мөн хүний эрхийн зөрчилтэй тэмцэх үүрэгтэй. | 6.  |
| 7. Тэгш байх зарчим | Ё. Хүний нэг эрх зөрчигдөхөд бусад эрх мөн зөрчигдөх үндэс болно. | 7.  |
| 8. Хариуцлага хүлээх зарчим | Ж. Хүний бүх эрх, эрх чөлөө адил тэгш хүчинтэй байх бөгөөд нэг эрх нь бусдаас илүү чухал, давуу гэж үзэж үл болно. | 8.  |

**8.2б.** Хүний эрхийн түүхийн талаар сурах бичгийн 63-65 дахь талаас уншиж танилцаарай.

- Хүний эрхийн тухай суурь баримт бичгүүдээс гурвыг сонгоорой.
- Тус бүрийн онцлогийг товч бичээрэй?



...............................................
...............................................
...............................................



...............................................
...............................................
...............................................



..................................................................
..................................................................

**8.2в.** Нэгдсэн Үндэстний Байгууллагаас (НҮБ) 1966 онд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дагалдуулсан хүний эрхийн доорх хоёр суурь гэрээг баталсан. Эдгээр гэрээ хүний тодорхой эрхүүдийг баталгаажуулах арга механизм болдог. Дараах асуултуудад хариулж бичээрэй.



1.Тухайн гэрээнд баталгаажуулсан эрх мөн бол **ТИЙМ,** биш бол **ҮГҮЙ** гэж тэмдэглэнэ.
2.Тухайн 2 гэрээнд заасан эрхүүдээс дутуу бичсэн эрх байгаа бол доорх зайнд нэмж бичээрэй.

| **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт** | **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт** |
|---|---|
| ___ Амьд явах | ___ Соёлын амьдралд оролцох |
| ___ Сурч боловсрох | ___ Ялгаварлан гадуурхалтаас ангид байх |
| ___ Эрх чөлөөтэй байх | ___ Хөдөлмөрлөх |
| ___ Үзэл бодлоо илэрхийлэх | ___ Хуулийн өмнө эрх тэгш байх |
| ___ Нийгмийн амьдралд оролцох | ___ Хэл, соёлоо хамгаалуулах |
| ___ Эрүүл мэндээ хамгаалуулах | ___ Амьжиргааны зохистой түвшинд амьдрах |
| ........................................ | ........................................ |
| ........................................ | ........................................ |
| ........................................ | ........................................ |

**8.2г.** Иргэд эрхээ эдлэхэд орон нутгийн захиргааны байгууллагуудын хүлээх, эс хүлээх үүргийг ялган өгөгдсөн тэмдгээр тэмдэглээрэй. ✔ ✘

☐ Хүндэтгэх үүрэг ☐ Хангах үүрэг ☐ Боловсролын үүрэг

☐ Халамжийн үүрэг ☐ Хамгаалах үүрэг ☐ Мэдээллийн үүрэг

**8.2г.** Төрийн зүгээс зарим бүлгийн гишүүдийн тэгш бус байдлыг арилгах зорилгоор “Хүний эрхийг хангах түр, тусгай арга хэмжээ” гэсэн хөтөлбөр хэрэгжүүлдэг.

| Яагаад түр, тусгай арга хэмжээ гэж нэрлэсэн бэ? | Түр, тусгай арга хэмжээг жишээгээр тайлбарлана уу. |
|---|---|
| | |

**8.2д.** Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.




**Асуулт.** Төр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд ямар байгууллагыг бүрдүүлэн ажиллах вэ?



..............................................................................................
..............................................................................................
..............................................................................................
....................................

**8.1е**. Ардчилсан нийгэмд хүний эрхийг ямар хоёр тохиолдолд хязгаарладаг вэ?.

01



02

**Өөрийгөө үнэлээрэй.**

**“Би хийж дууссан”** хэсэгт даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан, **“Би эргэлзэж байна”** хэсэгт дутуу хийсэн, **“Надад тусламж хэрэгтэй байна”** хэсэгт ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичээрэй.

| Би хийж дууссан | Би эргэлзэж байна | Надад тусламж хэрэгтэй байна | Багшийн үнэлгээ |
|---|---|---|---|
| | | | |

**8.3а.** Дараах өгөгдлийг уншиж, сурах бичгийн 64- 69 дахь талаас нэмэлт мэдээлэл цуглуулан асуултад хариулаарай.



*Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Өөрөөр хэлбэл хүний эрх нь жам ёсны зүйл бөгөөд хүнд өөрт нь угаас заясан хүнээс салшгүй зүйл тул хүний эдлэх эрхийг аль нэг төр эсвэл хэн нэгэн хүн хязгаарлан зөрчиж болохгүй юм.*

1. Хүний жам ёсны эрх гэдэгт юуг ойлгох вэ?

2. Яагаад жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийг олон улсын хүний эрхийн өдөр хэмээн дэлхий даяар тэмдэглэх болсон бэ?

3. Хүн эрхээ мэдэх нь ямар, ямар ач холбогдолтой вэ?

**8.3б.** Монгол улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт **“**Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.**”** хэмээн заасан. Хүнийг үл ялгаварлах эдгээр үзүүлэлтээс нэгийг сонгож, гол санаа, агуулгыг бичгээр болон зургаар илэрхийлээрэй.



**8.3в**.Тохиолдлыг шинжилж, асуултад хариулаарай.

**Тохиолдол 1:**
А нь дунд ангийн сурагч, гэр бүлийн хамт Улаанбаатар хотын нэгэн дүүрэгт оршин суудаг. Оршин суугаа дүүргийнхээ сургуульд сурах гэсэн ч дүүргийн сургуулиудын нэг ангид суух сурагчийн тоо гүйцсэн байв. Харин дүүрэг бүх хүүхдүүдээ сургуульд хамруулах зорилгоор гурван ээлжээр хичээллүүлэх болжээ. Сурагч А нь гуравдугаар ээлжид 40 сурагчидтай ангид суралцахаар болов.

**Тохиолдол 2:**
Тухайн сургуулийн 7 дугаар ангийн сурагч Ж, Г нар “Манай анги 48 хүүхэдтэй. Дунд ангид ороод харьцангуй цөөхөн хүүхэдтэй болсон. Түүнээс бага ангид 55-иас дээш хүүхэдтэй хамт хичээллэдэг байсан. Олон хүүхэдтэй нэг ангид суух нэг талаар хөгжилтэй ч зарим талаар их хэцүү. Бид 2-ын хувьд бага сургуульд байхдаа дандаа хамгийн ард суудаг байсан. Хичээл ойлгохгүй үе их гарна, олон хүүхэдтэй хамт суухаар анхаарал сарних үе ч бий. Гэхдээ одоо ч гэсэн зарим үед нэг ширээнд гуравуулаа суух үе гардаг. Тэр үед бол хичээл хийж чаддагүй” хэмээн ярьж байлаа.

Асуулт 1. Уг нөхцөл байдлыг сайжруулах, асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн захиргааны ямар байгууллага, хэнд, хэрхэн хандах вэ?



Асуулт 2. Яагаад заавал дүүргийнхээ сургуульд сурах ёстой вэ?



Асуулт 3. Дээрх хоёр тохиолдлоос сурагчдад учирч болох үр дагаврыг тодорхойлон хэлэлцээрэй.



**Өөрийгөө үнэлээрэй.**

**“Би хийж дууссан”** хэсэгт даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан, **“Би эргэлзэж байна”** хэсэгт дутуу хийсэн, **“Надад тусламж хэрэгтэй байна”** хэсэгт ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичээрэй.

|  **Би хийж дууссан** |  **Би эргэлзэж байна** |  **Надад тусламж хэрэгтэй байна** |  **Багшийн үнэлгээ** |
|---|---|---|---|
| | | | |

**Үгийн сүлжээг гүйцэтгэж, хичээлээ бататгаарай**







**Босоо:**

1. .......гэдэг нь хүн болж төрсний хувьд заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлбэл зохих эрх чөлөө, боломж
2. Хүний эрхийн хэдэн зарчим байдаг вэ?
3. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг боловсруулсан ажлын хэсгийн ахлагч
4. Хүний эрхийн зарчмуудын нэг
5. “Магна Харти” баримт бичигт гарын үсэг зурсан хаан

**Хөндлөн:**

1. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүргүүдийн нэг
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд баталгаажуулсан хүний эрхүүдийн нэг нь
3. 1945 онд хүний эрх, энх тайван, аюулгүй байдлыг хамгаалахын тулд байгууллагдсан байгууллага
4. Төрөлхийн бус ялгарлын нэг шинж
5. Онц байдал болон дайны үед хүний эрхийг хязгаарлаж болох баримт бичиг

Бүлэг: **Орон нутгийн удирдлага**
Сурагчийн овог, нэр:..........................

Эхэлсэн.... он.....сар.....өдөр....цаг
Дуусан.... он.....сар.....өдөр....цаг

| I | II | III |
|---|---|---|



Даалгаврыг анхааралтай уншиж зааврын дагуу хийж гүйцэтгээрэй.

8.1а. МУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын нэгжүүдийг чиг үүргээр нь эрэмблэн нэрлээрэй.



- Нийслэл ........................ .............................
- Аймаг .............................. ................................

**8.1б** Нутгийн өөрөө удирдах байгууллагыг тогтолцоог бичиж тайлбарлаарай. ямар тогтолцоотой :

1

2

3

**8.1в.** Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ИТХ-аас хурлаас нэр дэвшүүлдэг. Харин Засаг даргын бүрэн эрхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын тодорхой эрх бүхий субьект баталгаажуулдаг. Дараах тухайн Засаг дарга ба баталгаажуулах субьектыг зөв холбоорой.

1. Аймаг, Нийслэл
2. Сум, Дүүрэг
3. Баг, Хороо




A. Аймаг, Нийслэлийн Засаг дарга

B. Ерөнхий сайд

C. Сум, Дvvргийн Засаг дарга

8.1г. Засаг дарга гэж хэн бэ?

**8.1д.** Дараах товчилсон үгийг бүрэн үгээр нь бичээрэй.

ИНХ

ИТХ

**8.1е.** Дараах зайнд холбогдох ойлголтын нэр томьёог зөв нөхөн бичнэ үү.

1. Дүүргийн .............................. Төлөөлөгч нь тухайн дүүрэгт байнга оршин суугч, эсхүл дүүргийн нутаг дэвсгэр дэх байгууллага, аж ахуйн нэгжид ажил, хөдөлмөр эрхлэгч байна.
2. Аймаг, нийслэл, сумын ........................ төлөөлөгч нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугч байна
3. Баг, хорооны .................. дарга

**8.1ё.** Нутгийн өөрөө удирдах ёсны тодорхойлолтыг бичээрэй.



**8.1ж**. Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явцын үе шатыг зөв дараалуулан бичнэ үү.




**8.1з.** Орон нутгийн удирдлага нь нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулан хэрэгжүүлдэг. Эдгээр удирдлагын тухай дараах асуултуудад зөв хариулаарай.

1. Нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэгч нь хэн бэ?
   / /
2. Төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь хэн бэ?
   / /
3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажиллах хэлбэр нь юу вэ?
   / /
4. Орон нутгийн удирдлагыг хэдэн жил тутамд сонгодог вэ?
   / /

**8.1и.** Орон нутгийн хүрээнд шийдвэр гаргах үйл явц хэрэгжих боломжийг зөв илэрхийлсэн өгүүлбэрийн өмнө нь дугуйлан тэмдэглэнэ үү.

- Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчөөгүй байх.
- Орон нутагт гарч буй шийдвэрүүд нь нийтийн эрх ашигт үл нийцсэн байх.
- Шийдвэр гаргахдаа иргэдийн санал, хүсэлтийг тусгасан байна.
- Орон нутагт гарч буй шийдвэрүүд нь тухайн нутгийн иргэдийн оролцох боломжийг хангасан байх.
- Орон нутгийн шийдвэр нь зарим нэг дүрэм журмыг зөрчсөн байх.

**8.1й.** Орон нутгийн түвшинд хэрэгжих тушаал, тогтоол болон дүрэм, журмыг ямар байгууллага, аль албан тушаалтан гаргах вэ? Зөв хариулна уу.





**8.1к.** Аль субьект нь аль эрх зүйн актыг гаргах вэ? Зөв холбоорой.

| | |
|---|---|
| 1. ИНТ, ИТХ-ын тэргүүлэгчид | А. Тогтоол |
| 2. Бүх шатны Засаг дарга нар | Б. Захирамж, тушаал |

**8.1л.** Орон нутгийн түвшний бодлого шийдвэрт хүүхдүүд хэрхэн оролцох боломжтой вэ?

Хүүхэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийн гэсэн үзэл бодолтой байх эрхтэй

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц 13,14-р зүйлд

**8.1м.** Тухайн орон нутагт гарч буй бодлого, шийдвэрт хүүхдийн оролцоог хангах үүргийг ямар байгууллагууд гүйцэтгэх вэ? Гүйцээж бичээрэй.



- Хүүхдийн эрхийг хамгаалах зорилго бүхий төрийн байгууллагууд
- .
- .
- .
-

**8.1н.** Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн байгууллага гэж ямар байгууллага вэ?



**Өөрийгөө үнэлээрэй.**

2 од хэсэгт гүйцэтгэсэн даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан даалгаврын харгалзах дугаарыг, 1 хүсэл хэсэгт дутуу ойлгосон, ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичнэ үү.

| Хоёр од | Нэг хүсэл | Багшийн тэмдэглэл |
|---|---|---|
| | | |

**8.2а.** Шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтныг аль нь зөв дараалалд оруулсан байна вэ?

A. Дүүргийн засаг дарга - Аймгийн засаг дарга - Хорооны засаг дарга
B. Хорооны засаг дарга - Дүүргийн Засаг дарга - Нийслэлийн Засаг дарга
C. Нийслэлийн засаг дарга - Хорооны засаг дарга - Багийн дарга
D. Багийн дарга - Сумын засаг дарга - Нийслэлийн засаг дарга

**8.2б.** Орон нутгийн удирдлагын эрх, үүрэгт холбогдох дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

- Цэгийн оронд тохирох орон нутгийн удирдлагыг нөхөж бичээрэй.
- Тухайн хурлын эрх, үүрэг мөн бол **ТИЙМ,** биш бол **ҮГҮЙ** гэж ялган тэмдэглэнэ.
- Талбарт дутуу байгаа хурлын эрх үүргийг гүйцээн бичээрэй.

**Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал**

Тийм **БАГ, ХОРООНЫ** Засаг даргыг сонгох , ажлаас чөлөөлөх
___ ........, ........., ........., ......... эдийн засгийн асуудлыг хэлэлцэх
___ Зарим иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлэх
___ Тухай нутаг дэвсгэрт байгалийн баялгийг ашиглахыг хэлэлцэх
.......................................
.......................................

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал**

___ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх
___ ........, ........., ........., ......... Нийгмийн болон зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэх
___ ......... , ............... Иргэдээ шагналд тодорхойлох
___ Засаг даргыг томилох, ажлаас чөлөөлөх
___ ............, ..........., ........., ........ Төсвийг хэлэлцэн батлах

**8.2в.** Асуултын дагуу даалгаврыг гүйцэтгээрэй.




- Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1-д юу гэж заасан байдаг вэ? / сурах бичгийн 85 дахь тал гол санаа хэсгээс уншаарай./
- Орон нутгийн эрх мэдэл иргэдэд байдгийн шалтгаан юу вэ? Тайлбарлан бичээрэй.
- ..........................................................................................
..........................................................................................
- Орон нутгийн удирдлагыг иргэд шууд болон төлөөлөн бүрдүүлдэг талаар тус бүрд нь жишээ гаргана уу.






**8.2г.** Иргэд өөрсдөө болон төлөөлөн удирдах хүмүүстэй зөвлөлдөн хэлэлцэж оршин суугаа орон нутагтаа тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх нь ямар ач холбогдолтой вэ?



**8.2в.** Иргэд сонгуульд оролцож өөрсдийгөө төлөөлж бодлого тодорхойлох, шийдвэр гаргах төлөөлөгчөө сонгож байгаа бөгөөд иргэдийг төлөөлж, тэдний өмнөөс шийдвэр гаргаж буй хүн нь иргэдийн эрх ашиг, сонирхлыг хүндэтгэж, тэдний дуу хоолой болж, шийдвэр гаргахад нөлөөлж чадаж буй эсэх нь иргэдэд хамгийн их хамаатай байдаг. Тэгвэл хүүхдийн эрх ашигтай холбоотой асуудлыг орон нутгийн бодлого, шийдвэрт тусгах ямар боломж бидэнд байна вэ? Гүйцээн бичээрэй.



- Өөрийн оршин суугаа орон нутгийн шийдвэр гаргагчтай уулзах, зөвлөлдөх
- 
- 
- 
- 
- 
- 

**8.2д.** Хүүхдийн нэгдсэн зөвлөл нь тухайн орон нутагт хүүхдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажилладаг сонгуульт байгууллага юм. Энэ байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон бичнэ үү.



**Өөрийгөө үнэлээрэй.**

**“Би хийж дууссан”** хэсэгт даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан, **“Би эргэлзэж байна”** хэсэгт дутуу хийсэн, **“Надад тусламж хэрэгтэй байна”** хэсэгт ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичээрэй.

|  **Би хийж дууссан** |  **Би эргэлзэж байна** |  **Надад тусламж хэрэгтэй байна** |  **Багшийн үнэлгээ** |
|---|---|---|---|
| | | | |

Бүлэг: **Орон нутгийн удирдлага**
Сурагчийн овог, нэр:..........................

Эхэлсэн.... он.....сар.....өдөр....цаг
Дууссан.... он.....сар.....өдөр....цаг

| I | II | III |
|---|---|---|

**8.3а** Сурагч та өөрийн орон нутагт тулгамдаж байгаа нэг асуудлыг сонгон аваарай.

- Ямар шалтгааны улмаас асуудлыг сонгосон талаар үзэл бодлоо илэрхийлнэ үү.

- Уг асуудлыг хэрхэн шийдвэрлэхэд сурагч та ямар хувь нэмэр оруулж болох вэ?



- Энэ асуудал ямар шалтгааны улмаас үүссэнийг дүгнэж, ямар дарааллаар, хэрхэн шийдвэрлэх, ямар үр дүн гарч болох талаар өөрийн бодлыг дүгнэн бичээрэй.

**8.3б**. Орон нутгийн түвшинд ИНХ, ИТХ, Хурлын тэргүүлэгчид, бүх шатны Засаг дарга нарын гаргасан шийдвэрүүд нь 5 үе шатыг дамжин гардаг.

- Сурах бичгийн 87- 89 дахь талын “Асуудал шийдвэрлээрэй” гэсэн даалгаврыг анхааралтай уншаарай.
- Сонгосон асуудлаа дараах 5 үе шатны дагуу шийдвэрлэх талаарх жишээг тус бүрд нь бичээрэй.

Асуудлыг тодорхойлох

Асуудлыг судлах

Хувилбар боловсруулах

Шийдвэр гаргах

Шийдвэрийг хэрэгжүүлэх

**8.3б**. Орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд хүүхдүүдийн оролцоо чухал байдаг. Зааврын дагуу асуудал шийдвэрлэх мод зураарай.

1. Асуудлын ямар мод зурахаа төсөөлөн бодоорой.
2. Тулгамдаж буй асуудал нь олон нийтийг хамарсан байх хэрэгтэй. Олон асуудлыг сонгож болно. Сурах бичгийн 87 дахь талыг нэмэлт болгон уншаарай.
3. Зурсан асуудлын модоо тайлбарлаж, бусад хүүхдүүдийн саналыг аваарай.




1. Үндэс- Хүүхэд оролцоогоо эдлэх орчин гэж төсөөлнө. Үндэснээс мод ургана.
2. Модны иш- Сурагч та өөрөө.
3. Мөчир- Нийгмийн бүхий л орчныг авч үзнэ. Өөрөөр хэлбэл, бидний өмнө тулгамдсан шийдвэрлэх асуудлууд.
4. Навч - Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбаруудаа түүнд бичих.
5. Жимс- Тухайн асуудлыг шийдэх санал дэмжигдэх боломжтой үед жимс ургана.



